



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/140

Алтанбулаг

Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахыг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 171 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2230 жил, Их Монгол улс байгуулагдсаны 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Улсын баяр наадмыг цахимаар, радио телевизээр шууд дамжуулан хүргэж, үзэгчгүйгээр зохион байгуулах болсонтой холбогдуулан сумын хэмжээнд Улсын баяр наадмаас бусад баяр, уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт баяр, хурдан морины уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хориглосугай.

2. Малчин айл өрхүүдэд Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрч тусгаарлах байранд тээвэрлэн хүргэхэд мал, аж ахуйг сумын Онцгой комисс, тухайн иргэнтэй зөвшилцөн садан төрлийн хүмүүст хүлээлгэн өгөх ажлыг 1,2 дугаар багийн Засаг дарга (Б.Баттулга), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Жамбалдорж) нарт даалгасугай.

3. Цаг, уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн мэдээллийн дагуу 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд нийт нутгаар дуу цахилгаантай аадар бороо орох төлөвтэй байгаа тул үерийн далан, суваг, инженерийн байгууламжинд үзлэг, шалгалт зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгах, Гүн нуур, Гялаан нуур, голын эрэг дагуу үерийн усанд автаж болзошгүй малчин айл өрхүүдэд сэрэмжлүүлэг хүргэж, нүүлгэн шилжүүлэх ажил зохион байгуулж ажиллахын Байгаль хамгаалагч (З.Амарсайхан), (Г.Март), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Жамбалдорж) нарт үүрэг болгосугай.

4. Үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин хяналтын улсын байцаагч (С.Мөнхзул)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, Шуурхай штабын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГ